

# ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022/12/26-2022/12/30



## ХАМГИЙН ИХ ДҮНГЭЭР АРИЛЖИГДСАН

АПУ	1,392,214,597
Голомт Банк	1,388,680,478
Крипто Үндэстэн ХК	1,065,704,900
Инвескор ББСБ	1,040,689,425
Ард санхүүгийн	617,061,398

## ХАМГИЙН ИХ ӨСӨЛТТЭЙ

Крипто Үндэстэн ХК	1,065,704,900	<b>52.86%</b>
Тэнгэрлэг медиа групп	40,548,510	<b>26.21%</b>
Богд Банк	73,287,141	<b>17.04%</b>
Хорин хоёрдугаар бааз	60,126	<b>14.98%</b>
Эрдэнэс сольюшинс	1,853,431	<b>13.15%</b>

## ХАМГИЙН ИХ БУУРАЛТТАЙ

Монноос	120,600	<b>-15.49%</b>
Авто Импекс	32,163,967	<b>-12.26%</b>
УБ-Бүк	43,247	<b>-11.76%</b>
Ремикон	414,100	<b>-11.45%</b>
Баянгол зочид буудал	101,200,700	<b>-8.64%</b>

2022 оны сүүлчийн долоон хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээл дээр 65 компанийн 8.2 тэрбум ₮-ийн 19.4 сая ширхэг үнэт цаас арилжаалагдсан байна.

Үүнээс 1.09 тэрбум ₮-ийн ХБҮЦ, 100 сая ₮-ийн компанийн бонд, 173.1 сая ₮-ийн хамтын хөрөнгө оруулалт сан, 6.8 тэрбум ₮-ийн хувьцааны арилжаа хийгдсэн байна.

Топ 20 индекс 37,565.5 нэгжид хүрч 2.13-иар өссөн үзүүлэлттэй ба Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 6.88 их наяд ₮-т хүрээд байна.

Хөрвөх чадварын хувьд АПУ ХК-ийн хувьцаа тэргүүлж 1.4 тэрбум ₮-ийн арилжаа хийгдсэнээр дараах 5 компани нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 81%-ийг эзэлж байна.

Өнгөрсөн долоон хоногт Крипто үндэстэн ХК-ийн хувьцааны ханш хамгийн өндөр өсөлт үзүүлж үнийн дүнгийн хувьд ч мөн тэргүүлсэн байна.

Монноос ХК-ийн ханш 15.49%-иар буурч хамгийн өндөр уналт үзүүлсэн бол Авто Импекс, Баянгол зочид буудал ХК-ийн ханш харгалзан 12.26%, 8.64%-иар уналт үзүүлж үнийн дүнгийн хувьд тус ангилалд хамгийн өндөр дүнгээр арилжаалагдсан байна.

**Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж**

# ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022/12/26-2022/12/30

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Өнгөрсөн долоон хоногт “Монголын хөрөнгийн Бирж ТӨХК” хувьчлагдаж олон нийтэд 34% санал болгож 11.9 тэрбум ₮ татан төвлөрүүлхээр болсон.
- 12/30-ны байдлаар нийт захиалга 57.8 тэрбум ₮-т хүрч 485.62%-иар биелэлттэй хаагдаж нийтдээ 7,414 хөрөнгө оруулагч оролцсон байна.
- Энэхүү төслийн Үндсэн андеррайтер: **Инвескор капитал ҮЦК**, туслах андеррайтер: **Голомт капитал ҮЦК, Ти Ди Би Секьюритис ҮЦК**  
Аудитын компани: **Грант Торнтон Аудит ХХК**  
Хуулийн зөвлөх: **Эм ди эс энд Хаанлекс**  
Үнэлгээний компани: **Гэрэгэ Эстимэйт ХХК** тус тус оролцсон байна.
- Хувиарлалтын хувьд стратегийн хөрөнгө оруулагч 50%, жижиглэн хөрөнгө оруулагч нарт үлдсэн 50%-ийг хувиарлахаар боллоо.



- Голомт Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2023/1/13-ны өдөр бүртгэж 2023/2/2-ны өдөр 10:00 цагт Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхимд болохоор товлогдлоо.
- Даатгалын салбарын 3 дахь том тоглогч Тэнгэр даатгал Мандал даатгал ХК-ийн толгой компани болох Мандал санхүүгийн нэгдэлд шилжлээ.
- 2022/12/13-ны өдрөөс эхлэн ҮЦТХТ-ын үсгэн кодоод өөрчлөлт оруулж дуустал Кроипто үндэстэн ХК-ын арилжааг зогсоогоод байсан бол тус компанийн үсгэн кодоод өөрчлөлт оруулж /CNF болсон/ 2022/12/23-ны өдрөөс арилжааг сэргээсэн байна.

**Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж**

+976 75100575

info@rhinosinvest.mn

www.rhinosinvest.mn

